



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

Г Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор 7  
батлагдсан журамд нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д дор дурдсан агуулгатай 3.8<sup>1</sup>, 3.8<sup>2</sup>, 3.9.5<sup>1</sup>, 3.9.5<sup>2</sup>, 3.9.5<sup>3</sup>, 3.9.5<sup>4</sup>, 3.9.5<sup>5</sup>, 3.9.5<sup>6</sup>, 3.25 дахь заалтыг тус тус нэмсүгэй:

1/ “3.8<sup>1</sup>. Салбар нь 2-оос доошгүй орон тооны ажилтантай, арилжааны банкны салбарт өөрийн данстай байх бөгөөд даатгалын талаарх баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрдүүлж архивлахаас гадна даатгалын төлөөлөгч, даатгуулагч иргэдэд зориулан сургалт, сурталчилгаа хийж, компанийн төвөөс зөвшөөрсөн хэмжээнд нөхөн төлбөрийг биеэ даан шуурхай олгодог байвал зохино;

3.8<sup>2</sup>. Салбар нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд шуурхай албатай байх ба 24 цагаар дуудлага хүлээн авах суурин утастай, тээврийн ослын хохирлын хэмжээг газар дээр нь очиж тогтоох зориулалтын автомашинтай, даатгалын талаарх мэдээлэл оруулж хадгалах, шаардлагатай мэдээг мэдээллийн санд өгч нэгтгүүлэх интернэтэд холбогдсон программ хангамжтай байна.”;

2/ ”3.9.5<sup>1</sup>. Арилжааны банкны тухайн аймаг, орон нутаг дахь салбарт нээсэн даатгалын салбарын дансны дугаар;

3.9.5<sup>2</sup>. Жолоочийн хариуцлагын даатгалын тохиолдлыг шалгах шуурхай албаны бүтэц, бүрэлдэхүүн, зохион байгуулалтын талаарх танилцуулга;

3.9.5<sup>3</sup>. Салбарт ажиллуулах суурин утасны дугаар, интернэтэд холбогдсон эсэх магадлал, тухайн аймаг, орон нутагт бүртгэлтэй голлох хэрэглэгчдийн суурин утасны жагсаалтын хуулбар;

3.9.5<sup>4</sup>. Дуудлагын зориулалтын автомашины гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

3.9.5<sup>5</sup>. Мэдээллийн сангийн программ дээр ажиллах ажилтан холбогдох сургалтанд хамрагдсан талаарх танилцуулга;

3.9.5<sup>6</sup>. Салбараас даатгалын нөхөн төлбөр олгохтой холбогдсон журмын төсөл.”;

3/ ”3.25. Нэмэлт даатгалын хэлбэрийн зөвшөөрөл олгохын тулд Хорооноос уг даатгалын хэлбэртэй холбогдсон нарийн мэргэжлийн шинжээч ажиллуулах шаардлага тавьж болно. Энэ тохиолдолд даатгалын компани нь холбогдох мэргэжлийн шинжээчээр авч ажиллуулсан хүний тодорхойлолтыг тухайн мэргэжлээр их, дээд сургууль төгссөнийг нотлох дипломын хуулбарын хамт ирүүлнэ.”.

2. Журмын 3.9.2 дахь заалтын “...удирдлагын...” гэсний дараа “болон орон тооны ажиллагсдын”, 3.9.4 дэх заалтын “...төлөвлөгөө...” гэсний дараа ”болон даатгалын төлөөлөгч, даатгуулагч иргэдэд зориулсан сургалт, сурталчилгаа явуулах жилийн ажлын төлөвлөгөө;” гэж тус тус нэмсүгэй.

3. Нэмэлтийг журамд оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар/С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар/Д.Нямцэрэн/-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН